

Аудит хийх үндэслэл: Аудитыг аймгийн ИТХ-ын захиалгаар Улсын Их хурлын Төсвийн байнгын хорооны 2017 оны “Аудитын сэдэв батлах тухай” 2 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2017 оны А/12 дугаар тушаалыг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийв.

Аудитын ерөнхий дүгнэлт: **Засгийн газраас хэрэгжүүлсэн “Агро парк” төсөл бүрэн хэрэгжээгүй байна.**

**ЗАРИМ ТӨСӨЛ, ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР
ДҮН /АГРО ПАРК, ХҮЛЭМЖ ТӨСЛҮҮД/**



АГУУЛГА

Аудитын
тайланг
бэлтгэсэн:

Төв аймаг дахь
Төрийн аудитын
газар

Даргын үүргийг
түр орлон
гүйцэтгэгч
Ц.Хишигжаргал

Аудитын
менежер
О.Амаржаргал

Аудитор
Д.Пүрэвсүрэн
О.Сосор
Шинжээч
Ч.Загдсүрэн

2017 оны 05 дугаар
сарын 23

Уг тайланг АГ-ын
Веб сайтаас үзнэ
үү.
www.tuv-audit.mn

Аудитын тайлан,
дүгнэлттэй
холбоотой
асуудлаар нэмж
тодруулах, асууж
лавлах зүйл
байвал 70273463
дугаарын утас,
70272582 дугаарын
факсаар харилцана
уу.

ХАЯГ: Төв аймгийн
Төрийн захиргааны
II байр

Товчилсон үгийн тайлбар

3

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, шалгуур үзүүлэлт

4

БҮЛЭГ 1. Засгийн газраас хэрэгжүүлсэн Агро парк төсөл нь бүрэн хэрэгжээгүй байна.

1.1 Агро парк төслийн хүрээнд ТЭДС-аас 4.0 сая төгрөгийн бага оврын тракторын иж бүрдэл нийлүүлэхээс 1.9 сая төгрөгийн бага оврын тракторыг нийлүүлж, Засгийн газрын тогтоолыг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

6

1.2 Аймгийн ИТХ-аас гаргасан “гэрээний үүргээ бүрэн хангасан ашиглагчдад агро парк төслийн хөрөнгийг хувьчилах” шийдвэр хэрэгжээгүй байна.

8

БҮЛЭГ 2. Кангвон мужийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн хүлэмж төсөл 3 үе шаттайгаар амжилттай хэрэгжиж дууссан байна.

2.1 Солонгос улсын Кангвон мужийн хөрөнгө оруулалтаар 3 үе шаттай хэрэгжсэн хүлэмжийн аж ахуй нь аймгийн иргэдийг 1-8 шинэ нэр төрлийн жимс жимсгэнэ, нарийн ногоогоор хангаж, амжилттай хэрэгжиж дууссан байна.

12

2.2 Солонгос улсын хөрөнгө оруулалтаар хийгдсэн хүлэмжийн аж ахуйн талаар иргэн, аж ахуйн нэгжтэй аймаг орон нутгийн зүгээс ямар нэгэн гэрээ, хэлцэл хийгээгүй, хөрөнгийн бүртгэл, үнэлгээ хийгдээгүй байна.

17

Дүгнэлт

18

Зөвлөмж

19

Товчилсон үгийн тайлбар

МУ	Монгол Улс
УИХ	Улсын Их хурал
ЗГ	Засгийн газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ИТХТ	Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчид
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ААН	Аж ахуйн нэгж
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХК	Хувьцаат компани
ТЭДС	Тариалан эрхлэлтийг дэмжих сан
ХХААГ	Хүнс хөдөө аж ахуйн газар
ХХААЯ	Хүнс хөдөө аж ахуйн яам
ТБОНӨХБАҮХАТ	Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай
ТЭДС	Тариалан эрхлэлтийг дэмжих сан
ОНӨА	Орон нутгийн өмчийн алба

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, шалгуур үзүүлэлт**Аудитын зорилт:**

Засгийн газрын 2008 оны 136 дугаар тогтоолоор хэрэгжсэн агро парк төсөл болон Солонгосын Кангвон мужийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн хүлэмжийн аж ахуйн хэрэгжилт, үр дүнд аудит хийж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдэнэ. Аудитын зорилтыг хангахын тулд дараахь чиглэлээр аудит хийнэ. Үүнд :

- Агропарк төслийн хэрэгжилт, үр дүн
- Хүлэмж төслийн хэрэгжилт, үр дүн

Аудитын хамрах хүрээ:

Аудитад аймгийн ХХААГ болон сумдын ЗДТГ, агро парк, хүлэмж төсөлд хамрагдсан иргэн, аж ахуйн нэгжүүдийн ажлын гүйцэтгэлтэй холбоотой баримт материал, хөрөнгийн данс бүртгэл, хөрөнгийн ашиглалт, тооцоо, судалгаа болон холбогдох бусад баримт материалыг авч үзнэ.

Үндсэн мэдээлэл:

Засгийн газрын 2008 оны 136 дугаар тогтоолын “Агропарк төсөл”-өөр бүх сумдад 4.0 сая төгрөгийн трактор, 2.5 сая төгрөгийн хүлэмж, 5.0 сая төгрөгийн 30 тонны багтаамжтай зоорь нийт 11.0 сая төгрөг хөрөнгө оруулалт хийгджээ. Уг ажил нь улсын төсөв буюу Хүнс, хөдөө аж ахуйн сайдын төсвийн багцын хөрөнгөнөөс хэрэгжсэн байна. Тус тогтоолоор төслийг зохион байгуулах, хэрэгжилтийн явцад хяналт тавих, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, үйл ажиллагааны талаархи тайланг гаргахыг Хүнс, хөдөө аж ахуйн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага хэрэгжүүлэхээр заасан байна.

Мөн БНСУ-ын Кангвон мужийн тусламжтайгаар байгуулсан “Хүлэмжийн аж ахуйн”-г гурван суманд байгуулсан байна.

Эрсдлийн үнэлгээ:

Төлөвлөлтийн үе шатны ажлын явцад цуглуулж судалсан баримт, материал, хамрах хүрээ, нөхцөл байдалд хийсэн урьдчилсан дүн шинжилгээнд үндэслэн хийх аудитын эрсдлийн ерөнхий үнэлгээг “Дунд” гэж үзлээ.

Аудитын арга зүй:

Аудитыг гүйцэтгэхэд Төрийн хяналт шалгалтын стандарт, гүйцэтгэлийн аудитын удирдамж /АДБОУС 3000-3100/-ийг ашиглах, холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга авах, санхүүгийн тайлан бусад шаардлагатай баримт материалд тулгуурлан дүн шинжилгээ хийх бөгөөд аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээ, шалгах хуудасны дагуу нотлох зүйл цуглуулж, дүн, дүгнэлт, зөвлөмж боловсруулна.

Аудитад ашиглах шалгуур үзүүлэлтүүд:

Аудитад дараахь хууль, эрх зүйн актыг шалгуур үзүүлэлт болгон ашиглана. Үүнд:

- Төрийн аудитын тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль

- Засгийн газрын 2008 оны 136 дугаар тогтоол
- Солонгос улсын Кангвон мужтай байгуулсан гэрээ
- Холбогдох бусад хууль тогтоомж, эрхийн актууд

Аудит хийх бүрэлдэхүүн: Аудитыг аймгийн аудитын газрын Аудитын менежер О.Амаржаргал удирдан, аудитор Д.Пүрэвсүрэн, О.Сосор, шинжээч Ч.Загдсүрэн нар хийж гүйцэтгэв.

Аудитын хугацаа:

Аудитыг 2017 оны 5 дугаар сарын 1-нд эхэлж, 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор хүргүүлнэ.

Агропарк төслийн хэрэгжилт, үр дүн**Бүлэг 1****Засгийн газраас хэрэгжүүлсэн Агро парк төсөл нь бүрэн хэрэгжээгүй байна.****1.1 Төслийн хэрэгжилт, хөрөнгө оруулалтын үр дүн**

Агро парк төслийн хүрээнд ТЭДС-аас 4.0 сая төгрөгийн бага оврын тракторын иж бүрдэл нийлүүлэхээс 1.9 сая төгрөгийн бага оврын тракторыг нийлүүлж, Засгийн газрын тогтоолыг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

Монгол Улсын Засгийн газрын 2008 оны 70 дугаар тогтоолоор батлагдсан “Атрын гурав дахь аян”-тариалангийн хөгжлийн Үндэсний хөтөлбөрийн хүрээнд агропарк байгуулж шинээр тариалан эрхлэгчдэд төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэнэ тариалах, арчлах, хураах, хадгалах технологийг зааж сургах, техникээр үйлчлэх, хураан авсан ургацыг хадгалах, иргэдийн орлогоо нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор Засгийн газрын 136 дугаар тогтоолоор “Агро парк” төслийг баталжээ. Уг төслийг улсын төсөв буюу Хүнс, хөдөө аж ахуйн сайдын багцын хөрөнгөнөөс хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн байна. Төслийн хүрээнд улсын хэмжээнд буюу сум, дүүрэг бүрт 2.5 сая төгрөгийн 120м² талбай бүхий нийлэг хальсан хүлэмж, 4.0 сая төгрөгийн бага оврын тракторын иж бүрдэл, 5.0 сая төгрөгийн 30 тоннын багтаамжтай зоорь, нийт 11.5 сая төгрөгийн хөрөнгө оруулалтыг хийхээр батлагдсан байна. ХХААЯ-наас 2.5 сая төгрөгийн хүлэмжийг, тариалан эрхлэлтийг дэмжих сангаас 4.0 сая төгрөгийн бага оврын тракторыг, аймгийн ХХААГ нь ХХААЯ-наас зоорины санхүүжилтад ирсэн нийт 135.0 сая төгрөгийн санхүүжилтийг сум тус бүрт 5.0 сая төгрөгөөр олгосон байна.

Агро парк төслийг хэрэгжүүлэх зорилгоор 2008 оны 9 сард ХХАА-н сайдын “бага оврын тракторын хуваарь батлах тухай” 175 тоот тушаал гарч 4.0 сая төгрөгийн трактор нийлүүлэхээс 1.9 сая төгрөгийн трактор 26 ширхэгийг Төв аймагт хуваарилах шийдвэр гарчээ. Уг хуваарийн дагуу 26 суманд тракторыг хүлээн авсан байна. Аймгийн ХХААГ-аас зоорь барих ажлын гэрээг сумдын Засаг дарга нартай байгуулж, сумдад эрх шилжүүлж, ТБОНӨХБАҮХАТухай хуулийн дагуу 27 суманд худалдан авах ажиллагааг зохион байгуулж, 2009 оны 8 сараас санхүүжилтийг олгож эхэлсэн байна.

Уг тогтоолоор төслийг зохион байгуулах, хэрэгжилтийн явцад хяналт тавих, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, үйл ажиллагаанд хяналт тавих ажлыг Хүнс, хөдөө аж ахуйн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага хэрэгжүүлэхээр заасан байна. Үүний дагуу аймгийн ХХААГ-аас жил бүр хагас, бүтэн жилээр сумдад ажиллаж буй агро паркийн тайлан, мэдээг гаргаж ажилласан байна. Үүнд: төсөл хэрэгжснээс хойш нийт 311 удаагийн сургалтыг зохион байгуулж, 6158 хүнийг хамруулан, гарын авлагаар хангаж, жил бүр 5-8 төрлийн 30 гаруй мянган ширхэг үрслэгийг бойжуулж, 792 иргэний 1600 га талбайн хөрс боловсруулалтыг хийж ажилласан байна. 2009-2016 онуудад “Агропарк” төслийн хүрээнд нийт 182.9 га талбайд төмс, хүнсний ногоо, 1.93 га талбайд жимс, жимсгэнэ тарьж, 1824.5 тн төмс, хүнсний ногоо, 0.4 тн жимс, жимсгэнэ хураан авчээ. 2017 оны 5 сарын байдлаар агро парк төслийн хүрээнд үйл ажиллагаа явуулж буй 15 суманд 45 га-д төмс, 10 га-

д хүнсний ногоо, 0.3 га-д жимс, жимсгэнэ, хүлэмжийн 1350 м² талбайд 1-4 нэр, төрлийн нарийн ногоо тариалахаар хаврын тариалалтыг эхлээд байна. Мөн бага оврын трактороор 73 иргэнд 92 га талбайг боловсруулах үйлчилгээг үзүүлжээ.



Архуст суманд ашиглагдаж буй Агро парк төслийн хүрээнд хийгдсэн хөрөнгө /өнөөдрийн байдлаар/

Монгол улсын Засгийн газрын 2008 оны 136 дугаар тогтоолоор “Агро парк төсөл”-ийн хүрээнд сум бүрт 11.5 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийхээр батлагдсан боловч 9.6 сая төгрөгийн ажил хийгджээ. Энэ ажлын хүрээнд ТЭДС-аас 4.0 сая төгрөгийн бага оврын тракторын иж бүрдэл нийлүүлэхээс 1.9 сая төгрөгийн бага оврын тракторыг нийлүүлсэн нь Засгийн газрын тогтоолыг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

1.2 Төслөөр хэрэгжсэн хөрөнгийн ашиглалт, түүний эзэмшил

Аймгийн ИТХ-аас гаргасан “гэрээний үүргээ бүрэн хангасан ашиглагчдад агро парк төслийн хөрөнгийг хувьчилах” шийдвэр хэрэгжээгүй байна.

Монгол Улсын Засгийн газрын 2008 оны 136 дугаар тогтоолоор улсын төсөв буюу Хүнс, хөдөө аж ахуйн сайдын багцын хөрөнгөнөөс хэрэгжсэн “Агро парк” төслийн хүрээнд ХХААЯ-наас 2.5 сая төгрөгийн хүлэмжийг, тариалан эрхлэлтийг дэмжих сангаас 4.0 сая төгрөгийн бага оврын тракторыг, аймгийн ХХААГ-аас 5.0 сая төгрөгийн зоорь барих ажлыг сумдад эрх шилжүүлэн гүйцэтгүүлсэн.

Аймгийн ХХААГ-аас уг төслийн хэрэгжилтийн талаар ирүүлсэн мэдээ болон санхүүгийн баримтаар Агро парк төслийн хүрээнд сумдад олгосон трактор, зоорь, хүлэмжийн ашиглалт, данс бүртгэлд тусгасан байдлыг шалгахад:

-Засгийн газрын тогтоолоор сум тус бүрт 4.0 сая төгрөг, нийт 108.0 сая төгрөгийн бага оврын тракторын иж бүрдэл нийлүүлэгдэхээс Эрдэнэ суманд бага оврын трактор нийлүүлээгүй,

-Уг тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор гаргасан ХХАА-н сайдын 2008 оны 175 тоот тушаалд 4.0 сая төгрөгийн тракторыг 1.9 сая төгрөгөөр үнэлсэн байна. Аймгуудад хуваарилагдсан 1.9 сая төгрөгийн 26 ширхэг трактор сумдад орлого авагдаж, данс бүртгэлд тусгахаас 17 сум бага оврын трактор буюу нийт 30.5 сая төгрөгийг данс бүртгэлд тусгасан, Баян, Сүмбэр сумдууд данс, бүртгэлд тусгаагүй,

- Мөн Баянчандмань сум 4.0 сая төгрөгөөр, зургаан сум 2.5-3.8 сая төгрөгөөр, Архуст сум 1.7 сая төгрөгөөр гэх мэт данс, бүртгэлд үнийн зөрүүтэй тусгасан байна.

-5.0 сая төгрөгийн зоорийг 27 суманд барьж, ашиглалтад оруулахаас 25 суманд зоорийг актаар хүлээн авч ашиглалтад оруулсан байна. Сүмбэр, Баянхангай сумдад зоорийн санхүүжилтэд 5.0 сая төгрөгийг олгосон боловч актаар хүлээлгэн өгч, ашиглалтад оруулаагүй байна. Гэвч Сүмбэр сум 5.0 сая төгрөгийн зоорийг орлогодсон байна.

-Нийт 25 сумын 125.0 сая төгрөгийн зоорийг данс, бүртгэлд тусгахаас 24 сум 121.1 сая төгрөгийн зоорийг данс бүртгэлд тусгаж, Баян, Баянцогт сумд данс бүртгэлд тусгаагүй, Аргалант сум 1.1 сая төгрөгөөр илүү орлогодсон байна.

-2.5 сая төгрөгийн өртөгтэй хүлэмжийг 24 сум данс бүртгэлд тусгаж, зарим сумд буюу Аргалант сум 10.8 сая төгрөгөөр, Жаргалант сум 4.1 сая төгрөгөөр үнийн зөрүүтэй данс бүртгэлд тусгасан байна.

Баян сум нь агро паркийн хөрөнгийг анх ашиглалтад ороход сумын иргэн У.Жамцтай гурвалсан гэрээ байгуулж, хүлээлгэн өгсөн боловч данс бүртгэлд тусгаагүй байна.



Баян сумын иргэн Жамцын ашиглаж буй хөрөнгө

Данс, бүртгэлд бүртгэгдсэн дээрхи төслийн хөрөнгөнд нягтлан бодох бүртгэлийн дагуу элэгдэл тооцогдох боловч сум бүр харилцан адилгүй элэгдэл тооцсон, зарим сумд огт элэгдэл тооцоогүй байна. Үүнд:

-24 суманд 121.1 сая төгрөгөөр данс бүртгэлд бүртгэгдсэн 5.0 сая төгрөгийн өртөг бүхий зооринд нийт 60.8 сая төгрөгийн элэгдэл тооцогдож, үлдэгдэл өртөг 60.3 сая төгрөг байна. Бүрэн, Угтаал сумд огт элэгдэл тооцоогүй байна.

-26 суманд 74.9 сая төгрөгөөр бүртгэгдсэн 2.5 сая төгрөгийн өртөг бүхий хүлэмжинд нийт 53.1 сая төгрөгийн элэгдэл тооцогдож, үлдэгдэл өртөг 22.4 сая төгрөг байна. Элэгдлийг тооцож үзвэл

-24 суманд 56.1 сая төгрөгөөр бүртгэгдсэн 1.9 сая төгрөгийн өртөг бүхий бага оврын тракторт нийт 44.0 сая төгрөгийн элэгдэл тооцогдож, 8.3 сая төгрөгийн үлдэгдэл өртөгтэй байна.

Эдгээр хөрөнгийн элэгдлийг Засгийн газрын 2005 оны 233 дугаар тушаалын 2 дугаар хавсралтаар батлагдсан “үндсэн хөрөнгийн элэгдэл тооцоход баримтлах хугацаа, жилд байгуулах элэгдлийн хэмжээ”-г үндэслэн тооцож үзвэл:

д/д	Хөрөнгийн нэр	Анхны үнэ	ашиглах жил	ашигласан жил	элэгдлийн хувь	байгуулсан элэгдэл	үлдэгдэл өртөг
1	Зоорь	5.0	20	7	5	1.8	3.2
2	Хүлэмж	2.5	10	7	10	1.8	0.7
3	Трактор	1.9	7	7	14	1.9	0

Аймгийн ИТХТ-ийн хуралдааны 2009 оны 36 тоот тэмдэглэлээр агро парк төслийн хөрөнгийн эзэмшигчийг тодорхой болгох, хөрөнгийг урт хугацаагаар, тогтвортой, үр ашигтай ажиллах нөхцлийг хангах зорилгоор 2 жилийн гэрээгээр ашиглуулж, гэрээний үүргээ бүрэн хангасан ашиглагчид анхны үнээр нь хувьчилах шийдвэр гарсан байна. Үүний дагуу Батсүмбэр, Баян өнжүүл сумд агро паркын хөрөнгийг худалдан борлуулж хувьчилсан байна. Үүнд:

-аймгийн ИТХ-ын 2013 оны 46 тоот тогтоолоор Батсүмбэр сумын ЗДТГ-т бүртгэлтэй бага оврын трактор, хүлэмжийн үлдэгдэл өртөг нийт 3.5 сая төгрөгийг төлсөн тул хөрөнгийг данснаас хасах,

-Баян өнжүүл сум аймгийн ИТХТ-ын 2016 оны 12 сарын 22-ны өдрийн 66 тоот тогтоолын дагуу бага оврын тракторыг 0.3 сая төгрөгөөр худалдан борлуулжээ.

Агропарк төслөөр хэрэгжсэн хөрөнгө оруулалтын эзэмшигч, ашиглалт нь:

-Данс, бүртгэлд бүртгэлтэй 121.1 сая төгрөгийн 24 зоорьноос 14 нь ашиглагдаж байна. Үүнээс сумын ЗДТГ-ийн эзэмшилд байдаг 14 зоориноос 7 нь ашиглагддаг, 9 иргэн, 1 аж ахуйн нэгж 10 зоорийн эзэмшигч, ашиглагч бөгөөд 7 нь ашиглагдаж байна. Мөн данс бүртгэлд тусгаагүй боловч Баян суманд иргэн, Баянцогт суманд сургууль нь ашиглаж, эзэмшдэг байна.

-Данс, бүртгэлд бүртгэлтэй 74.9 сая төгрөгийн 26 хүлэмжээс 14 хүлэмж ашиглагдаж байна. Эдгээрээс 10 хүлэмж ЗДТГ-ийн эзэмшилд байдаг бөгөөд 4 хүлэмжийг ашигладаг, үлдсэн 16 хүлэмжийг иргэн, аж ахуйн нэгж эзэмшдэг бөгөөд 10 хүлэмж ашиглагдаж байна.

-Данс, бүртгэлд бүртгэлтэй 56.1 сая төгрөгийн 24 тракторноос 2 трактор хувьчлагдаж, 10 трактор ашиглагдаж, Сүмбэр сумын трактор данс бүртгэлд тусгагдаагүй, эзэмшигч болон ашиглалт нь тодорхойгүй байна. Үүнээс 9 трактор сумын ЗДТГ-ийн эзэмшилд байгаагаас 5 трактор ашиглагдаж, 12 трактор иргэн, аж ахуйн нэгжийн эзэмшилд байгаагаас 8 трактор ашиглагдаж байна.





Баян өнжүүл сумын ашиглалтгүй байгаа хөрөнгүүд

Агро парк төслийн хүрээнд аймгийн бүх суманд хэрэгжсэн тус бүр 9.6 сая төгрөгийн хөрөнгийг аймгийн ИТХ-аас гэрээний үүргээ бүрэн хангасан ашиглагчдад хувьчилах шийдвэр хэрэгжээгүй байна.

Хүлэмж төслийн хэрэгжилт, үр дүн**Бүлэг 2**

Кангвон мужийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн хүлэмж төсөл 3 үе шаттайгаар амжилттай хэрэгжиж дууссан байна.

2.1 Төслийн хэрэгжилт, хөрөнгө оруулалтын үр дүн

Солонгос улсын Кангвон мужийн хөрөнгө оруулалтаар 3 үе шаттай хэрэгжсэн хүлэмжийн аж ахуй нь аймгийн иргэдийг 1-8 шинэ нэр төрлийн жимс жимсгэнэ, нарийн ногоогоор хангаж, амжилттай хэрэгжиж дууссан байна.

Аймгийн Шууд харилцаат Солонгос улсын Кангвон мужаас ХААЯ болон Төв аймгийн хамтын ажиллагааг хөгжүүлэх, Монгол улсад хөдөө аж ахуйн технологи нэвтрүүлэх зорилгоор “Кангвоны хөдөө аж ахуйн хотхон” төслийг 3 үе шаттай хэрэгжүүлж 3 хотхон байгуулж, хэрэгжиж дууссан байна.

1-р үе шат 2004-2006 он /Борнуур хүлэмжийн хотхон/

2-р үе шат 2006-2010 он /Зуунмод хүлэмжийн хотхон/


3-р үе шат 2011-2015 он /Баянчандмань хүлэмжийн хотхон/

Уг төслийн зорилго нь:

- Нарийн болон жимст ногоог тариалан нутагшуулах
- Таримлын нэр төрлийг олшруулах
- Шинэ дэвшилтэт техник технологи нэвтрүүлэх
- Эрчимжүүлэлтийг үйлдвэрлэлд нэвтрүүлэх
- ААН, иргэдийг сургалт, мэдээллээр хангах
- Дадлагажуулах
- Хүлэмжний аж ахуйг хөгжүүлэх
- Аймаг мужийн гадаад харилцааг бэхжүүлэх

Төсөл хэрэгжих хугацаанд Кангвон мужаас жил бүр дараах материалыг нийлүүлсэн байна.

- Ногооны үр -9 төрөл
- Ургамал хамгаалалын бодис -2 төрөл
- Эрдэс бордоо -3 төрөл
- Үрслэг хийх хиймэл хөрс
- Хөрс хучих нийлэг хальс
- Дулаалгын хучилтийн материал
- Сойлтын уяа
- Нийлэг хальсийг нийлүүлсэн байна.



1 шат болох Борнуур сумын хүлэмжийн аж ахуй нь:

- Зуны хүлэмжийн талбай 1500 мкв
- Нийт 1 га-д 8 нэр төрлийн хүнсний ногоо, төмс тариалдаг
- Төмс жилд дунджаар 3-5 га-д тариалдаг.
- Байнгын 4 ажилчинтай / ногоочин-3, сахиул-1/
- Сүүний Фермертэй -17 үнээтэй,

Борнуур сумын хүлэмжийн аж ахуй

	Төслийн хөрөнгөөр		Өөрийн хөрөнгөөр		
	Хөрөнгийн нэр	Тоо хэмжээ	Хөрөнгийн нэр	Тоо хэмжээ	Бүгд үнэ /сая төгрөг/
1	Зуны нийлэг хальсан хүлэмж 1500 м ² /6м х 50 м/	5 ш	Зуны нийлэг хальсан хүлэмж /6мх 20м/	7 ш	8.4
2	Явган трактор /мотоблок/	1 ком	Хашаа	150*150м2	1.0
3	Хамар татагч	1ш	Худаг	1 ш	12.0
4	Контейнер /40 тн/	2ш	Блокон агуулах	1 ш	2.0
5	Худаг	1ш	Фермийн барилга	9*15 м2	8.0
6	зах банзаар барьсан хашаа	100*120 м2			
7	Бүгд				23.0

Тус хүлэмжийн аж ахуй нь:

- 4 хүнийг байнгын ажлын байраар,
- 10-15 хүнийг түр ажлын байраар хангадаг,
- Хүлэмж болон хучлагатай хөрсний үйлдвэрлэл эрхэлж ургамлын ургах тохиромжтой нөхцлийг бүрдүүлж өгч эрт ургацын ногоог 6-н сарын эхээр хурааж, сумынхаа зах зээлд нийлүүлдэг,

-Жил бүр дундажаар 30-65 хүнд талбайн сургалт, өдөрлөгийг зохион байгуулдаг,

- Шинэ нэр төрлийн тарималууд тарьдаг,
- Хүнсний ногооны үрслэгээр үйлчилгээ үзүүлдэг,
- Хүлэмж шинээр барих ажлыг зааж сургадаг байна.

Зуунмод сумын хүлэмжийн аж ахуй нь:

- Зуны хүлэмжийн талбай 3000 мкв
- Нийт 1-1,2 га-д 8 нэр төрлийн хүнсний ногоо, төмс тариалдаг.
- Төмс 3 га-д тариалдаг.
- Байнгын 10 ажилчинтай /Агрономч-1, ногоочин-8, сахиул-1/

Зуунмод сумын хүлэмжийн аж ахуй

Төслийн хөрөнгөөр			Өөрийн хөрөнгөөр		
1	Хөрөнгийн нэр	Тоо хэмжээ	Хөрөнгийн нэр	Тоо хэмжээ	Бүгд үнэ /сая төгрөг/
2	Зуны нийлэг хальсан хүлэмж 1500 м ² /6м х 50 м/	10 ш	Зуны нийлэг хальсан хүлэмж 1000м ²	1ш	130.0
3	Явган трактор /мотоблок/	1 ком	Зуны нийлэг хальсан хүлэмж 300м ²	1ш	7.2
4	Хамар татагч	1ш	өвлийн хүлэмж 1200м ²	2 ш	260.0
5	Контейнер /40 тн/	2ш	Шилэн хүлэмж 2000м ²	1 ш	120.0
6	зах банзаар барьсан хашаа	100*120 м ²	Худаг	9*15 м ²	8
7			Агуулах 120м ²	1 ш	40.0
			Ногооны зоорь 40тн	1ш	60.0
			блокон хашаа 5.1 га	1ш	
			Өндөр хүчдэл 200м	1ш	
	Бүгд				625.2

Тус хүлэмжийн аж ахуй нь:

- 10 хүнийг байнгын ажлын байраар
- 6-8 хүнийг түр ажлын байраар хангадаг.
- Эрт ургацын ногоог 6-н сарын эхээр хурааж, сумынхаа зах зээлд нийлүүлдэг.
- Жил бүр дундажаар 260-395 хүнд талбайн сургалт, өдөрлөгийг улс, аймгийн хэмжээнд ХААЯ, аймгийн ХХААГ-тай хамтран зохион байгуулдаг.
- Шинэ нэр төрлийн тарималыг /гүзээлзгэнэ, тарвас, амтат гуа/ ургуулж, тариалах технологийг үйлдвэрлэлд туршиж нэвтрүүлсэн.
- Баян, Бүрэн, Баян-Өнжүүл, Архуст, Эрдэнэ сумдын агропаркийн

эрхлэгчдийг 7-10 хоног дадлагажуулан сургасан.



Баянчандмань хүлэмжийн аж ахуй нь:

- Нийт талбайн хэмжээ 3 га, ашиглаж байгаа хүлэмжийн талбай 1000 мкв
- 5-6 хүнийг түр ажлын байраар хангасан

Баянчандмань сумын хүлэмжийн аж ахуй

Төслийн хөрөнгөөр			Өөрийн хөрөнгөөр		
1	Хөрөнгийн нэр	Тоо хэмжээ	Хөрөнгийн нэр	Тоо хэмжээ	Бүгд үнэ /сая төгрөг/
2	Зуны нийлэг хальсан хүлэмж 1500 м ² /6м х 50 м/	3ш	Зуны нийлэг хальсан хүлэмж /6мх 50м/	2 ш	12.0
3	Явган трактор /мотоблок/	1 ком	Хашаа	150*150м2	18.0
4	Хамар татагч	1ш	Эрчим хүчний шугам	1 ш	11.0
5	Контейнер /40 тн/	2ш			
6	Худаг	1ш			
	Бүгд				29.0

ХХААГ-аас ирүүлсэн мэдээгээр эдгээр 3 хүлэмжийн аж ахуйнууд нь анх байгуулагдснаас хойш:

№	Тарималын нэр	Сэргэлэн сумын хүлэмж			Баянчандмань сумын хүлэмж			Борнуур сумын хүлэмж		
		Тарьсан талбайн хэмжээ /м2/	1м2-аас авсан ургац /кг/	Нийт ургац /тн/	Тарьсан талбайн хэмжээ /м2/	1м2-аас авсан ургац /кг/	Нийт ургац /тн/	Тарьсан талбайн хэмжээ /м2/	1м2-аас авсан ургац /кг/	Нийт ургац /тн/
1	Өргөст хэмх	8100	86.8	68.48	1800	19.7	7.41	6000	129.8	58.50
2	Улаан лооль	5100	52.5	25.3				2400	16.43	5.10
3	Мини лооль	2100	28	10.4	1200	13.2	3.96	2400	11.03	4.21
4	Чинжүү	1500	12.7	3.81				3700	24.43	6.62
5	Амтат гуа	1200	9.9	2.97	1500	6.9	1.47			
6	Хулуу	3000	48.5	14.85				3300	31.63	8.55
7	Гүзээлгэнэ	2300	0.6	0.32				600	1.35	0.16
8	Тарвас	8300	51.4	36.19				1000	7.90	2.37
9	Кимчи байцаа									
10	Гашуун чинжүү									
11	байцаа									
12	Навчит ногоо									
ДҮН		31600		162.32	4500		12.84	19400		85.51

Хүснэгтээс харахад тус төсөл хэрэгжснээс хойш 3 хүлэмж нь нийт 55500 га талбайд 1-8 төрлийн 260 тн жимс, жимсгэнэ, нарийн ногоог тариалсан байна.

Мөн 2016 оны 2 дугаар сараас 4 дэхь шатны төсөл буюу 2016-2019 он хүртэл 4 жилийн хугацаатай хөдөө аж ахуйн 3 хотхоныг түшиглэн 4 дэхь шатны төслийг хэрэгжүүлэхээр гэрээ байгуулагджээ. Уг төслөөр уг 3 хотхоныг дадлага хийлгэх түшиц бааз болгон тариаланчдыг сургах хөтөлбөр хэрэгжүүлэх бөгөөд 2020 оноос Төв аймаг бие даасан үйл ажиллагаа явуулахаар болсон байна.

Солонгос улсын Кангвон мужийн хөрөнгө оруулалтаар 3 үе шаттай хэрэгжсэн хүлэмжийн аж ахуй нь аймгийн иргэдийг 1-8 шинэ нэр төрлийн жимс жимсгэнэ, нарийн ногоогоор хангаж, амжилттай хэрэгжиж дууссан байна.

2.2 Төслөөр хэрэгжсэн хөрөнгийн ашиглалт, түүний эзэмшил

Солонгос улсын хөрөнгө оруулалтаар хийгдсэн хүлэмжийн аж ахуйн талаар иргэн, аж ахуйн нэгжтэй аймаг орон нутгийн зүгээс ямар нэгэн гэрээ, хэлцэл хийгээгүй, хөрөнгийн бүртгэл, үнэлгээ хийгдээгүй байна.

Кангвон муж, Төв аймгийн хамтын ажиллагааны хүрээнд хүлэмжийн аж ахуй байгуулах гэрээг аймаг, мужийн удирдлагууд байгуулсан байна. Уг төслийн хүрээнд хэрэгжсэн 3 хүлэмжийн аж ахуйн эзэмшигч буюу ашиглагч нь:

- Сэргэлэн сум Т.Баярхүү /Атрын шим ХХК/
- Баянчандмань сум Б.Агваансодном
- Борнуур сум Д.Лхагва-Эрдэнэ гэсэн иргэд байна.

Солонгос улсын хөрөнгө оруулалтаар хийгдсэн эдгээр хүлэмжийн аж ахуйн талаар иргэн, аж ахуйн нэгжтэй аймаг орон нутгийн зүгээс ямар нэгэн гэрээ, хэлцэл хийгээгүй, хөрөнгийн бүртгэл, үнэлгээ хийгдээгүй байна.

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараахь дүгнэлт хийж байна.

1. Монгол улсын Засгийн газрын 2008 оны 136 дугаар тогтоолоор “Агро парк төсөл”-ийн хүрээнд сум бүрт ТЭДС-аас 4.0 сая төгрөгийн бага оврын тракторын иж бүрдэл нийлүүлэхээс 1.9 сая төгрөгийн бага оврын тракторыг нийлүүлсэн нь Засгийн газрын тогтоолыг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

2. Агро парк төслийн хүрээнд сум тус бүрт 9.6 сая төгрөгөөр хэрэгжсэн хөрөнгийг аймгийн ИТХ-аас тэмдэглэлээр өгсөн үүргийн дагуу “гэрээний үүргээ бүрэн хангасан ашиглагчдад хувьчлах шийдвэр” бүрэн хэрэгжээгүй байна.

3. Солонгос улсын Кангвон мужийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн хүлэмжийн аж ахуй нь аймгийн иргэдийг 1-8 шинэ нэр төрлийн жимс жимсгэнэ, нарийн ногоогоор хангаж, төсөл амжилттай хэрэгжсэн байна.

4. Солонгос улсын хөрөнгө оруулалтаар хийгдсэн хүлэмжийн аж ахуйн талаар иргэн, аж ахуйн нэгжтэй аймаг орон нутгийн зүгээс ямар нэгэн гэрээ, хэлцэл хийгээгүй, хөрөнгийн бүртгэл, үнэлгээ хийгдээгүй байна.

5. “Хүлэмж”, “Агропарк” төслийн хэрэгжилтийн байдалд аймгийн ИТХ-ын захиалгаар хийгдсэн гүйцэтгэлийн аудит нь төслийн хэрэгжилт, цаг хугацааны хувьд хэтэрхий оройтсноос аудитаар хангалттай үр дүн гарахгүй байна.

ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн аймгийн Засаг дарга Ж.Батжаргал, ХХААГазрын дарга Б.Жамбалдорж, ОНӨАлбаны дарга Д.Батжаргал нарт зөвлөх нь:

1.Агро парк төслийн хүрээнд сум тус бүрд хэрэгжсэн 9.6 сая төгрөг нийт 257.3 сая төгрөгийн хөрөнгийг аймгийн ИТХ-аас тэмдэглэлээр өгсөн чиглэлийн дагуу хувьчлах, худалдах замаар өмчлөлийн асуудлыг шийдвэрлэх

2.Солонгос улсын хөрөнгө оруулалтаар хийгдсэн хүлэмжийн аж ахуйн төсөл хэрэгжүүлэгч иргэн, аж ахуйн нэгжийн ашиглаж байгаа хөрөнгөнд аймаг орон нутгийн зүгээс хөрөнгийн бүртгэл, үнэлгээ хийлгэн, эзэмшиж ашиглах гэрээ, байгуулан ажиллах

Тайлан бичсэн: Аудитор
Аудитор
Шинжээч

Д.Пүрэвсүрэн
О.Сосор
Ч.Загдсүрэн

Тайланг хянасан: Менежер
Даргын үүргийг түр
орлон гүйцэтгэгч

О.Амаржаргал
Ч.Хишигжаргал

Холбогдох байгууллагын санал


ТӨВ АЙМГИЙН
ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗАР
41100 Зуунмод сум, Төв аймаг
Утас/факс: 70273092

2017.06.19 № 321
танай 2017.06.16 -ны 1/380 -т

ТӨВ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАРТ

“Зарим төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт, үр, дүн”
/Агропарк, хүлэмж төсөл/-д хийсэн гүйцэтгэлийн аудитын
дүгнэлт зөвлөмжтэй танилцлаа.
Дүгнэлтэнд санал байхгүй болно.

ДАРГА

Б.ЖАМБАЛДОРЖ



Ч.Зарим-Орлов

Төрийн аудитын газар
Хүндэтгэл

2017.06.22

07 5 4

ИНААГ: Alban bichig: 100t A5